



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/206/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| <p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Хэнтий аймаг Чингис хот 2024 он</p> | <p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК-ийн Захирал: Х.Ариунзул Утас: 11-450410 Цахим хаяг: ikhayadaudit@gmail.com</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024-03-11 № 287
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.ГАНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,980.0 мянган төгрөгийг машин тоног төхөөрөмж, 227.0 мянган төгрөгийг тавилга эд хогшил зэргийг худалдан авч, Боловсрол, шинжлэх ухааны газраас 38,396.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан ба хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

232420363

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсрол олгох 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн төсвийг 87.32 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 99,669,547.00 | 219,083,706.75 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 25,965,078.00 | 141,750,035.75 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 25,965,078.00 | 141,750,035.75 |
| 31210 | Төгрөг | 25,965,078.00 | 141,750,035.75 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 25,965,078.00 | 141,750,035.75 |
| 33 | АВЛАГА | 1,274,878.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,274,878.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 72,429,591.00 | 77,333,671.00 |
| 35100 | Түүхий эд материал | 877,755.00 | 888,755.00 |
| 35130 | Эм боох материал | 877,755.00 | 888,755.00 |
| 35400 | Хангамжийн материал | 71,551,836.00 | 76,444,916.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,928,200.00 | 3,609,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,785,060.00 | 12,776,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 161,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,906,200.00 | 7,903,170.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 43,932,376.00 | 51,995,546.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,547,946,168.18 | 2,519,100,597.39 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,547,946,168.18 | 2,519,100,597.39 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,531,425,168.18 | 2,502,711,597.39 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,573,169,084.00 | 2,573,169,084.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (126,454,573.56) | (176,707,079.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 84,197,692.96 | 124,574,232.96 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (52,411,922.04) | (63,761,235.01) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,397,900.90 | 81,624,900.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (41,864,110.40) | (48,958,172.10) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 22,241,795.00 | 22,841,795.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (14,656,954.34) | (15,878,184.26) |
| 39217 | Ном | 5,806,255.66 | 5,806,255.66 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 16,521,000.00 | 16,389,000.00 |
| 39301 | Программ хангамж | 430,000.00 | 430,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (331,000.00) | (463,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,422,000.00 | 16,422,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,647,615,715.18 | 2,738,184,304.14 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 3,644,138.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,644,138.00 | - |
| 41300 | Өглөг | 3,644,138.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 431,188.00 | - |
| 41360 | Бусад өглөг | 3,212,950.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,212,950.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,643,971,577.18 | 2,738,184,304.14 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,643,971,577.18 | 2,738,184,304.14 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 374,073,288.46 | 374,073,288.46 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 374,073,288.46 | 374,073,288.46 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,187,046,059.51 | 2,281,258,786.47 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (456,165,925.67) | 2,187,046,059.51 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,643,211,985.18 | 94,212,726.96 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 82,852,229.21 | 82,852,229.21 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,647,615,715.18 | 2,738,184,304.14 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,478,663,306.69 | 1,137,103,840.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,685,199,406.69 | 41,351,540.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,685,199,406.69 | 41,351,540.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 103,500.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,500.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,615,445,220.69 | 38,996,540.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 69,650,686.00 | 2,355,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 793,463,900.00 | 1,095,752,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 652,999,700.00 | 980,829,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 652,999,700.00 | 980,829,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 140,464,200.00 | 114,923,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 140,464,200.00 | 114,923,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 835,451,321.51 | 1,042,891,113.04 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 835,451,321.51 | 1,042,891,113.04 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 832,452,606.51 | 1,042,427,017.62 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 486,264,966.00 | 631,264,238.44 |
| 210101 | Үндсэн цалин | 417,768,485.00 | 504,064,155.44 |
| 210102 | Нэмэгдэл | 42,394,842.00 | 118,997,661.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 4,221,182.00 | 8,202,422.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,880,457.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 61,319,969.00 | 80,254,964.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,688,571.00 | 54,050,383.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,907,749.00 | 6,593,680.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,412,158.00 | 5,244,195.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,496,091.00 | 1,306,205.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,815,400.00 | 13,060,499.87 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 112,118,244.00 | 113,459,104.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,635,204.00 | 8,780,064.58 |
| 210302 | Түлш, халаалт | 102,923,040.00 | 102,923,040.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,560,000.00 | 1,756,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 369,360.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 369,360.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 89,569,287.00 | 120,708,640.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | - |
| 210502 | Хоол, хүнс | 89,569,287.00 | 120,708,640.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 468,000.00 | 999,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 468,000.00 | 999,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 82,342,780.51 | 95,740,269.79 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,763,728.00 | 21,949,659.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 80,000.00 | 3,741,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 67,499,052.51 | 70,049,110.79 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,998,715.00 | 464,095.42 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,998,715.00 | 464,095.42 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,998,715.00 | 464,095.42 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 2,643,211,985.18 | 94,212,726.96 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 2,643,211,985.18 | 94,212,726.96 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|---|-----------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 793,567,400.00 | 1,095,752,300.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 103,500.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 103,500.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 103,500.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,500.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 793,463,900.00 | 1,095,752,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 652,999,700.00 | 980,829,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 652,999,700.00 | 980,829,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 140,464,200.00 | 114,923,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 140,464,200.00 | 114,923,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 767,602,322.00 | 977,760,342.25 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 767,602,322.00 | 977,760,342.25 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 764,603,607.00 | 977,296,246.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 482,498,654.00 | 630,420,548.44 |
| 210101 | Үндсэн цалин | 378,491,191.00 | 474,301,705.91 |
| 210102 | Нэмэгдэл | 78,614,274.00 | 147,916,420.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 3,512,732.00 | 8,202,422.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,880,457.00 | - |
| 210106 | Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 61,319,969.00 | 80,254,964.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,688,571.00 | 54,050,395.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,907,749.00 | 6,593,671.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,926,400.00 | 5,244,193.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 981,849.00 | 1,306,202.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,815,400.00 | 13,060,502.16 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 112,118,244.00 | 113,459,104.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,635,204.00 | 8,780,064.58 |
| 210302 | Түлш, халаалт | 102,923,040.00 | 102,923,040.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,560,000.00 | 1,756,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,238,100.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,238,100.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 89,995,842.00 | 119,705,610.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | - |
| 210502 | Хоол, хүнс | 89,995,842.00 | 119,705,610.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 468,000.00 | 999,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 468,000.00 | 999,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 285,000.00 | 1,695,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 285,000.00 | 1,695,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,679,798.00 | 30,761,219.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,688,764.00 | 25,651,819.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,991,034.00 | 5,109,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,998,715.00 | 464,095.42 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,998,715.00 | 464,095.42 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,998,715.00 | 464,095.42 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 25,965,078.00 | 117,991,957.75 |

| | | | |
|--------|---|---------------|----------------|
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 2,207,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 2,207,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 2,207,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 2,207,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - | (2,207,000.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 25,965,078.00 | 115,784,957.75 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 25,965,078.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 25,965,078.00 | 141,750,035.75 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 374,073,288.46 | 82,852,229.21 | (456,165,925.67) | 759,592.00 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 374,073,288.46 | 82,852,229.21 | (456,165,925.67) | 759,592.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,643,211,985.18 | 2,643,211,985.18 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 374,073,288.46 | 82,852,229.21 | 2,187,046,059.51 | 2,643,971,577.18 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 374,073,288.46 | 82,852,229.21 | 2,187,046,059.51 | 2,643,971,577.18 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 374,073,288.46 | 82,852,229.21 | 2,187,046,059.51 | 2,643,971,577.18 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 94,212,726.96 | 94,212,726.96 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 374,073,288.46 | 82,852,229.21 | 2,281,258,786.47 | 2,738,184,304.14 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|-------------|---|-------------------------|-------------------------|-----------------------|--------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,121,716,700.00 | 979,503,246.83 | 142,213,453.17 | 87.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,121,716,700.00 | 979,503,246.83 | 142,213,453.17 | 87.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,121,716,700.00 | 979,503,246.83 | 142,213,453.17 | 87.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 749,886,600.00 | 630,420,548.44 | 119,466,051.56 | 84.0 |
| 210101 | Үндсэн цалин | 512,435,100.00 | 474,301,705.91 | 38,133,394.09 | 92.5 |
| 210102 | Нэмэгдэл | 221,202,200.00 | 147,916,420.53 | 73,285,779.47 | 66.8 |
| 210104 | Урамшуулал | 16,249,300.00 | 8,202,422.00 | 8,046,878.00 | 50.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 93,736,300.00 | 80,254,964.81 | 13,481,335.19 | 85.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,740,400.00 | 54,050,395.44 | 9,690,004.56 | 84.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,498,900.00 | 6,593,671.22 | 905,228.78 | 87.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,999,200.00 | 5,244,193.42 | 755,006.58 | 87.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,500,000.00 | 1,306,202.57 | 193,797.43 | 87.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,997,800.00 | 13,060,502.16 | 1,937,297.84 | 87.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 113,923,000.00 | 113,459,104.58 | 463,895.42 | 99.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,200,000.00 | 8,780,064.58 | 419,935.42 | 95.4 |
| 210302 | Түлш, халаалт | 102,923,000.00 | 102,923,040.00 | (40.00) | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,756,000.00 | 44,000.00 | 97.5 |
| 2105 | Нормативт зардал | 125,905,600.00 | 119,705,610.00 | 6,199,990.00 | 95.0 |
| 210502 | Хоол, хүнс | 125,905,600.00 | 119,705,610.00 | 6,199,990.00 | 95.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 999,800.00 | 200.00 | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 999,800.00 | 200.00 | 99.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,703,200.00 | 1,695,000.00 | 8,200.00 | 99.5 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,703,200.00 | 1,695,000.00 | 8,200.00 | 99.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,562,000.00 | 32,968,219.00 | 2,593,781.00 | 92.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,452,400.00 | 27,858,819.00 | 2,593,581.00 | 91.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,109,600.00 | 5,109,400.00 | 200.00 | 100.0 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,121,716,700.00 | 1,095,288,204.58 | 26,428,495.42 | 97.6 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 980,829,300.00 | 980,829,300.00 | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 980,829,300.00 | 980,829,300.00 | - | 100.0 |

| | | | | | |
|------------|---|-----------------------|-----------------------|-------------------|-------------|
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 114,923,000.00 | 114,458,904.58 | 464,095.42 | 99.6 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 114,923,000.00 | 114,458,904.58 | 464,095.42 | 99.6 |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 25,964,400.00 | - | 25,964,400.00 | 100.0 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 25,965,078.00 | - | - |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 141,750,035.75 | - | - |
| 3 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 34 | 34 | - | 100.0 |
| 6 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 17 | 17 | - | 100.0 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 16 | 16 | - | 100.0 |
| 15 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 270 | 270 | - | 100.0 |
| 24 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | | | |
| 28 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 18 | 18 | - | 100.0 |
| 33 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 16 | 16 | - | 100.0 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа илрээгүй ба 1 зөрчил¹ илэрснээс алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|----------|----------|--------------------------------------|-----|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 104 нэр төрлийн 484 ширхэг 68,509.8 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгүүдийг шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 1 | - | | | | | 1 | - | | | | |

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.